



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 325

Улаанбаатар хот

### Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

“Монгол Кувейтын байгаль хамгаалах төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2018, 2019 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар тус үйлдвэрийн газар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчиж давхардсан дүнгээр 210 сая төгрөгийн авлага, өглөгийг тооцоо хийж баталгаажуулаагүй, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасныг зөрчин 9,9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 48 дугаар зүйлийн 48.1-д заасныг тус тус зөрчин 138,1 сая төгрөгийн худалдан авалт хийсэн, Хөдөлмөрийн тухай хууль, Үйлдвэрийн газрын дотоод журам зөрчиж 29,7 сая төгрөгийн цалин олгосон, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэр, журмыг зөрчиж 29,9 сая төгрөгийн зөрүүтэй дүнгээр хөрөнгө бүртгэсэн зэрэг нийт 417,7 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрсэн, Үндэсний аудитын газраас 2019 оны санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөхөөс татгалзсан, захирлын контрактын биелэлт “Хангалтгүй” үнэлэгдсэн зэргийг тэмдэглээд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 6, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 50 дугаар зүйлийн 50.2, Контрактын 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Монгол Кувейтын байгаль хамгаалах төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс /Ц.Баяр-Эрдэнэ/-т дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

2.1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай байгуулсан Контрактын гэрээний үүргээ “Хангалтгүй” биелүүлсэн “Монгол Кувейтын байгаль хамгаалах төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Д.Энхтөмөрийг холбогдох хууль тогтоомж, контрактад заасны дагуу үүрэгт ажлаас нь чөлөөлөх арга хэмжээ авах;

2.2. “Монгол Кувейтын байгаль хамгаалах төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрэмд заасан үндсэн чиг үүрэг, зорилтын хэрэгжилт, төлөвлөлт, ашиг орлогын байдалд дүн шинжилгээ хийж, бодлогын яамтай хамтран шийдвэрлэх арга хэмжээ авах.

3. “Монгол Кувейтын байгаль хамгаалах төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Д.Энхтөмөрийн контракт хугацаа дууссан болон төрийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захирал зарцуулалттай холбоотой үүссэн нөхцөл байдлыг харгалзан үзээд захирал томилогдох хүртэл хугацаанд Төрийн өмчийн удирдлага,

000595

зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнийг 2020 оны 07 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн төрийн өмчийн төлөөлөгчөөр түр томилсугай.

4. Ц.Баяр-Эрдэнээр тус үйлдвэрийн газрын захирлын албан үүргийг хавсран гүйцэтгүүлж, санхүүгийн баримтад 1 дүгээр гарын үсэг зурах, өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах эрхийг олгосугай.

5. Ц.Баяр-Эрдэнэд тус үйлдвэрийн газрын захирлын албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл хөлсийг зохих журмын дагуу тооцож олгохыг “Монгол Кувейтын байгаль хамгаалах төв” төрийн өмчит үйлдвэрийн газарт зөвшөөрсүгэй.

6.“Монгол Кувейтын байгаль хамгаалах төв” төрийн өмчит үйлдвэрийн газарт түр томилогдох төрийн өмчийн төлөөлөгчид холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

6.1.Ажлын хэсэг байгуулж төрийн өмчийн эд хөрөнгийн тооллого хийж баталгаажуулах, мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээнд хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх;

6.2.Төрийн Аудитын байгууллагад тус үйлдвэрийн газрын 2019 оны санхүүгийн тайланд төлөвлөгөөт бус Аудит хийлгэх талаар албан бичгээр санал хүргүүлж, аудит хийлгэх.

6.3.Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал гаргасан, хяналт тавьж ажиллах үүргээ хангалтгүй биелүүлсэн “Монгол Кувейтын байгаль хамгаалах төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын ажилтны хөдөлмөрийн гэрээг хууль тогтоомжид нийцүүлэн цуцлах хүртэл арга хэмжээ авах.

7.Цаашид “Монгол Кувейтын байгаль хамгаалах төв” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын шинээр томилогдох гүйцэтгэх удирдлагад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

7.1.Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангах, санхүүгийн сахилга батыг хэвшиүүлж, зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байх;

7.2.Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, хөрөнгийн бүртгэл, хөтлөлт, тайлагналыг хууль тогтоомжид нийцүүлэх;

7.3.Орлого, зардлын тэнцвэрт харьцаа, үр ашгийг бодитойгоор тодорхойлон ажил, үйлчилгээний үнэ тарифыг батлан мөрдөж ажиллах;

7.4.Авлага, өглөгийг тооцоо нийлж, актаар баталгаажуулах, барагдуулах арга хэмжээ авч ажиллах;

7.5.Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ыг мөрдөх, хүчин төгөлдөр бус болон бүрдэлгүй анхан шатны баримтаар ажил гүйлгээ хийхийг таслан зогсоох;

7.6.Жижиг мөнгөн сангийн хэмжээг нарийвчлан тогтоох, бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний төлбөрөөс бусад тохиолдолд бэлэн мөнгөний зарлагын гүйлгээ хийхгүй байх;

7.7.Хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй эд хөрөнгө олж авах, бүртгэхийг таслан зогсоох;

7.8.Худалдан авах ажиллагаанд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах;

7.9.Аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг зохион байгуулж, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллах.

8.“Монгол Кувейтын байгаль хамгаалах төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт, холбогдох тогтоол шийдвэрийн хэрэгжилт, хандивлагч байгууллагаас үл хөдлөх хөрөнгөд хийсэн хөрөнгө оруулалтад хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс /Д.Нарангэрэл/-т үүрэг болгосугай.

9.Тогтоолын биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

10.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ  
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц. ТҮВШИНЗАЯА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2020 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн  
З.С. дугаар тогтоолын хавсралт

“Монгол Кувейтын байгаль хамгаалах төв” төрийн өмчилт  
үйлдвэрийн газарт хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил,  
дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт ..

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Хамрах хугацаа	Мөнгөн дүн /төгрөгөөр/	Зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Хууль, журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтлөх, нягтлан бodoх бүртгэлийн тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж, 2019 оны санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулаагүй.	2019	-	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1, Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 8.4, захиралтай байгуулсан контрактын 3.2.6-д заасныг мөрдөж ажиллах, төлөвлөгөөт бус аудит хийлгэх арга хэмжээ авч ажиллах.
2	Авлага, өглөгийг зөрүүтэй дүнгээр тусгасан, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй	2018-2019	210,011,464.52	Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д заасныг мөрдөж ажиллах. /Давхардсан дүнгээр/
3	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгүй худалдан авалт хийсэн, шатахуун, мах худалдан авалтын нийт төсөвт өртгийг үндэслэн харьцуулалт хийгээгүй	2018-2019	138,105,847.1	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг мөрдөж ажиллах.
4	Захирал Д.Энхтөмөр нь анхан шатны баримтаар нотлогдоогүй илүү цагийн хөлсийг тооцуулж авсан.	2019	7,154,489.074	Хөдөлмөрийн тухай хуулийн 53.2, захиралтай байгуулсан Контрактын 4.3, Дотоод журмын 6.1.1-д заасныг мөрдөж ажиллах.
5	Менежер Т.Гэрэлмаа нь хөдөлмөрийн гэрээгүй цагийн ажилтанд цагийн бүртгэл хөтөлж, цалин тооцуулсан. Захирал хууль зөрчиж зардал гаргасан, тайлан тэнцэлд тусгаагүй.	2019	22,641,000.00	Хөдөлмөрийн тухай хуулийн 23 <sup>3</sup> .3 дахь заалтыг мөрдөж ажиллах. Хөдөлмөрийн тухай хуулийн 131.1, Дотоод журмын 8.1.1-д заасны дагуу арга хэмжээ авах.
6	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээс зөрүүтэй дүнгээр үндсэн хөрөнгө, бараа материалын дансанд хөрөнгө бүртгэсэн.	2018-2019	29,893,825.31	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах.
7	Эрх бүхий байгууллагаас баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө оруулалт хийсэн	2018-2019	9,893,200.00	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.8 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж, авах, шилжүүлэх журам”-ын 3.1 дэх заалтыг мөрдөж ажиллах.
	<b>НИЙТ ДҮН</b>		<b>417,699,826.00</b>	